

# МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

## ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№ 11/337

НШУС

2010

### МОНГОЛЧУУДЫН ӨРТӨӨНИЙ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ СҮРИЙН ГУРВАН ИХ БЭЛГЭ ТЭМДЭГ (ЗАРЛИГИЙН БИЧИГ, ЗАРЛИГИЙН ТАМГА, ЗАРЛИГИЙН ГЭРЭГЭ)

Бүрээчин дархан\*

\* Өвөр Монголын Их сургуулийн Монгол судлалын дээд сургуулийн профессор  
Хөрвүүлсэн Л.Норовсүрэн

**Түлхүүр үг:** монгол өртөө, эрх сүр, зарлигийн бичиг, зарлигийн тамга, зарлигийн гэрэгэ.

**М**онголчуудын өртөөний мэдээллийн системд зарлигийн тамга, зарлигийн гэрэгэ бол онц чухал байр суурьтай юм. Энэ нь голдуу тэдний харьцалшгүй их эрх сүр дээр илэрч байдаг аж. Эрх сүр бол монголчуудын өртөөн мэдээллийн чухал их бэлгэ тэмдэг мөн.

Их Монгол улс 1206 онд байгуулагдсаны дараа нийгмийн байгууллын шинж чанартай тохиролцсон хүмүүсийн хоорондох нийгмийн шинэ харилцаа бий болж, монголчуудын засаг захиргаа нь их хаанаар төв болгосон, түмэн, мянган, зуун, арваны байгууллыг хэрэгжүүлж, хаант төрд тамгын түшмэл тавьж, дүрэмтэй болж, хаант төрийн зарлиг заавар, зар тунхаг, захиа зарлалыг хаант төрөөс нэгдэлтэй зохион байгуулж туурвин бичих ба тараан явуулах дүрэмжилтэй болж, үүний улмаас бүх улсын өнцөг булан бүрт нэвтэрсэн интер сүлжээ мэт өртөө улаанууд буй болов.

Их Монгол улсын үед Хархориноор төв болгосон өртөө улаагийн систем эхлэн бүрэлджээ. «Монголын нууц товчоо»-ны төгсгөлийн хэсэг, тухайлбал Өгөөдэй хааны дөрвөн их гавьяа дутагдлыг бичсэн хэсэгт монголчууд өртөө улаагийн байгуулал байгуулсан түүхэн учрыг тодорхой тэмдэглэн үлдээсэн байдаг. Эрдэмтдийн бүртгэснийг үндэслэвэл Их Монгол улсын сүүлчийн үеэр 120 гаруй өртөө (морь, үхэр, тэмээ зэрэг улаатай) бий болов гэнэ. Хаант төрийн зарлиг захиаг эдгээр өртөө эл газарт дамжуулан хүргэдэг байжээ.

Их Юань улсын үед, монголчуудын засаг захиргаанд хувиралт гарч, мужаар гол болгосон хятад маягийн засаг захиргааны байгууллыг хэрэгжүүлснээс уул нь түмэн, мянган, зуун, арваны засаг захиргааны байгуулал нь зөвхөн цэргийн явдлын шинж чанартай зохион байгуулалт болж хувираад, хаан төрийн зарлиг захиаг муж холбосон бага өртөө улаа гүйцэтгэх болов. Эрдэмтдийн бүртгэснийг үндэслэвэл Их Юань улсын үед Дайдшанд, Хархорин зэрэг хаан балгасаар гол төв болгосон их бага өртөө улаа нийт

1400 гаруй (морь, үхэр, тэмээ, нохой, онгоц зэрэг улаатай) байв гэнэ. Зарлиг заавар, зар тунхаг, захиа зарлал бол өртөөн мэдээллийн гол мэдээлэгдэхүүн болох бөгөөд эдгээр нь заавал хас тамгат бичиг байх ёстой, хас тамгат бичиг биш бол өртөөгөөр уламжлагдаж чадахгүй, зарлигийн гэрэгэ байхгүй бол өртөө улаагаар зарлиг заавар, зар тунхаг, захиа зарлал уламжилж болохгүй юм. Тийнхүү зарлигийн бичиг, зарлигийн тамга, зарлигийн гэрэгэ бол монголчуудын өртөөний мэдээллийн гурван их чухал зангилаа гэж хэлж болно.

### Нэг. Зарлигийн бичиг

Зарлигийн бичиг гэж Их Монгол ба Их Юань улсын үед Монголын их хаан, Монголын дөрвөн их хан улсын хад, улсын ван, төрийн сайд, цэргийн юаншуай, хааны багш зэрэг хүмүүсээс улсын дотооддоо буулгасан буюу улсын гадаадад илгээсэн эл зүйлийн бичиг материалыг зааж буй.

**З**арлигийн бичигт хаан (буюу хан)-ы зарлиг захиа ч хаад төрийн хууль зарлал, албан мэдээ, зар тунхаг, нот бичиг, жуух бичиг, улаагийн бичиг зэрэг багтаж байдаг бөгөөд тэдгээр нь агуулгын талаар, улс төр (алтан ургийнхны их хуралдай, их орд суух), аж ахуй (гааль татвар, алба гувчуур хураах), цэргийн явдал (бусдыг байлдан дагуулах, бослого урвалгыг дарангуйлах), гадаад харилцаа (хэлэлцээр хийх, гэрээ тогтоох), шашин суртахуун (хааны багш өргөмжлөх, шашин дэлгэрүүлэх) зэрэг үйл багтаж байдаг аж.

Зарлигийн бичгийг монгол (уйгаржин, дөрвөлжин), хятад, перс, дөрвөд зэрэг бичгээр бичиглэж, хаан (буюу хан)-ы

хасбуу тамга, улсын ван, төрийн сайд, цэргийн юаншуай, хааны багшийн хас тамгыг дараад өртөө улаагаар дамжуулан хүргэдэг байна. Үүнд: Монголын их хааны зарлигийн бичгийг бол «зарлиг» гэж, Монголын дөрвөн их хан улсын хадын зарлигийн бичгийг бол «үг» гэдэг байжээ. «Хааны улаагийн зарлигийн бичиг» (Pu Ma Sheng Zhi) бол өртөө улаагаар дамжин явах үед хэрэглэдэг бичиг материал болно. Хуучны үгэнд «хааны зарлиг харьшгүй, эзний зарлиг эргэшгүй» гэдэг үг байдаг. Энэ бол хааны зарлиг нэгэнтээ гарвал харц ард үг дуугүй дагаж журамлана гэсэн үг билээ.

Зарлигийн бичгийн харьцалшгүй их эрх сүрийн онцлог шинж нь «Мөнх тэнгэрийн хүчин дор, хааны суу дор», «Тэнгэрийн хүчин хааны суу мэдтүгэй», «Мөнх тэнгэр мэдэг», «Тэнгэрийг залбирч их үйлийг огоот нэгэн зүг болгоё», «тэнгэрийн хүчин дор», «тэнгэр мэдтүгэй», «Үг биш болгосон хүн их энх алдаст болтугай» гэх мэт үг үсгийг онцолж хэрэглэсэнд бий. Үүнд ялангуяа: «алдас» гэдэг үгийг хэрэглэж байвал алах ялаар шийтгэнэ гэсэн үг болох юм. Өмнөд Сүн улсын элчин Пян Даяа «Хар татарын тухай хэргийн товч» гэх номдоо «Ял хийвэл алахыг алдас гэдэг»<sup>1</sup> гэж бичсэн нь тухайн үеийн байдлыг сайтар харуулж байгаа юм.

Их Монгол ба Их Юань улсын үед Монголын их хаад, Монголын дөрвөн их хан улсын хадаас улсын дотооддоо буулгасан буюу улсын гадаадад илгээсэн зарлигийн бичгүүд гэвэл "Өгөөдэй хааны зарлигийн бичиг" (1240 он), "Гүюг хаанаас Ромын шашны хаан IV Инносентэд илгээсэн бичиг" (1246 он), "Мөнх хаанаас

Францын улсын ван Х Луист илгээсэн бичиг" (1254 он), "Аваа ханаас католик шашны элчинд олгосон үнэмлэх бичиг" (1267 он буюу 1279 он), "Хубилай хааны үхэр жилийн зарлигийн бичиг" (1277 он буюу 1289 он), "Аргун ханаас Францын Филипп хаанд илгээсэн бичиг" (1289 он), "Аргун ханаас IV Николаст илгээсэн бичиг" (1290 он), "Өлзийт хааны үхэр жилийн зарлигийн бичиг" (1301 он), "Хасан ханаас VIII Бонифаст илгээсэн бичиг" (1302 он), "Өлзийт султанаас Францын Филип хаанд илгээсэн бичиг" (1305 он), "Буянт хааны бар жилийн зарлигийн бичиг" (1314 он), "Гэгээн хааны гахай жилийн зарлигийн бичиг" (1323 он), "Тогоонтөмөр хааны туулай жилийн зарлигийн бичиг" (1351 он), "Тогоонтөмөр хааны бичин жилийн зарлигийн бичиг" (1368 он) зэрэг бий.

Үүнд: "Өгөөдэй хааны зарлигийн бичиг" бол одоогоор олж мэдсэн хамгийн анхны их хааны хасбуу тамгат зарлигийн бичиг болно. Тус зарлигийн бичгийг Өгөөдэй хааны арван хоёрдугаар он, тухайлбал он тооллын 1240 онд буулгасан байна. Зарлигийн бичгийн уул хятад эх ба "Еин (тамга) мину. Үг биш болгосон хүн их энх алдаст болтугай! Энэ бичиг хулгана жил"<sup>2</sup> гэх Өгөөдэй хааны цохолборт чулуун хөшөө нь эдүгээ Хянэн мужийн Жи Юань Шяаны арван зүгийн их Чи ве гүн сүмд хадгалагдаж буй. Зарлигийн бичгийн уул хятад эхийн он, сар, өдөр дээр Өгөөдэй хааны зарлигийн тамгыг дарж буй (тамгын хятад бичгийг уншин таньж чадав, тус өгүүллийн хоёрдугаар хэсэгт үзэгтүн). Энэхүү зарлигийн бичгийг 1255 онд эрдэмтэн Цай Ме Бюу анх удаа "Юань улсын үеийн Хятадын хар яриагаар бичсэн хөшөөнүү-

дийн эмхтгэл" гэх номдоо нийтэлсэн байна.

"Гююг хаанаас Ромын шашны хаан IV Инносентэд илгээсэн бичиг"-ийг 1248 оны намар Их Монгол улсын гуравдугаар үеийн их хаан Гююг, их орд суух үед Ромын шашны хаан IV Инносентэд илгээсэн байжээ. Зарлигийн бичгийг 20 см урт цаасан дээр перс үсгээр бичсэн бөгөөд хааны зарлигийн тамгыг зарлигийн бичгийн ард дарсан байна<sup>3</sup>. Энэхүү зарлигийн бичгийг 1920 онд Польшийн эрдэмтэн Кирил Керелефаск Ватиканы архиваас илрүүлсэн бөгөөд түүнийг 1923 онд Францын эрдэмтэн Поль Пеллио анх удаа "Монголчууд ба католик шашны төр" гэх номдоо нийтэлсэн байна<sup>4</sup>.

"Хубилай хааны үхэр жилийн зарлигийн бичиг" бол Хубилай хаанаас Дайюуван Фогийн Ши Би Ше сүмд буулгасан зарлигийн бичиг болно. Энэхүү зарлигийн бичгийг эрдэмтэн Франк илрүүлсэн бөгөөд анх удаа өөрийн өгүүлэл зохиолдоо нийтэлсэн байна<sup>5</sup>.

"Буянт хааны бар жилийн зарлигийн бичиг"-ийн чулуун хөшөөнд сийлэгдсэн дөрвөлжин үсгийн эх ба түүний хятад орчуулга нь эдүгээ Хенэн мужийн Аньянд хадгалагдаж байна. Дахивал мөн Буянт хааны 1312 он ба 1317 онд дөрвөлжин үсгээр чулуунаа бичиглэж, хааны зарлигийн тамга дарсан зарлигийн бичгийн уг эх нь эдүгээ Гуандун мужийн Нэн Хуа Ши сүмд хадгалагдаж буй<sup>6</sup>.

"Аваа ханаас католик шашны элчинд олгосон үнэмлэх бичиг", "Аргун ханаас IV Николаст илгээсэн бичиг", "Хасан ханаас VIII Бонифаст илгээсэн бичиг" зэргийг 1921 онд эрдэмтэд Ватиканы нууц архиваас тус тус олж илрүүлсэн ба "Аргун

ханаас Францын Филип хаанд илгээсэн бичиг", "Өлзийт султанаас Францын Филип хаанд илгээсэн бичиг"-ийг 1924 онд Францын эрдэмтэн Авел Ремосат Франц улсын архиваас илрүүлжээ<sup>7</sup>.

**А**ваа, Аргун, Хасан, Өлзийт зэрэг хэдийн уйгаржин монгол үсэг бүхий зарлигийн бичгүүд бол тухайн үеийн Их Монгол улсын улс төр, цэргийн явдал, гадаад харилцаа, шашин суртахуун зэрэгт холбогдсон маш төлөөлөх чанартай зарлигийн бичгүүд болохыг онцлон дурдууштай байна. Эдгээр зарлигийн бичгүүдэд бүр ханы хасбуу тамга дарж байна.

### Хоёр. Зарлигийн тамга

Зарлигийн тамга гэж Их Монгол ба Их Юань улсын үед, Монголын их хаад, Монголын дөрвөн их хан улсын хад, улсын ван, төрийн сайд, цэргийн юаншуай, хааны багш жич, хааны соёрхолд багтсан өртөөний тамга зэрэг албан тамгуудыг зааж буй. Зарлигийн тамга бол эрх сүрийн чухал бэлгэ тэмдэг болох төдийгүй, хоёр этгээдийн нийгмийн харилцаанд бат итгэмжийн үйлдлийг үзүүлэх дархан эрхт багаж зэвсэг болох юм. Үүнд: Монголын их хаад, Монголын дөрвөн их хан улсын хадын зарлигийн тамгыг бол "Хасбуу тамга" гэж, улсын ван, төрийн сайд, цэргийн юаншуай, хааны багш зэрэг ихэсүүдийн зарлигийн тамгыг бол "хас тамга" гэдэг байна. Монголын их хаад ба Монголын дөрвөн их хан улсын хадын зарлигийн тамгын эрх сүр бол харьцуулшгүй их байдаг юм. Тухайлбал: "Мөнх тэнгэрийн хүчин дор Их Монгол улсын далай хааны зарлиг, ил болго иргэн дор хүрвээс биширтүгэй, аюутугай!"

гэдгийн эрх сүр бол харьцуулшгүй их байдаг аж.

Сурвалж бичгүүдэд тэмдэглэснийг үндэслэвэл монголчууд XIII зууны эхний үеэс зарлигийн тамгын учир ёсыг олж таньсан ба түүнийг төрийн чухал хэрэг явдалд идэвхтэй хэрэглэдэг болжээ. "Юань улсын түүх"-ийн "Тататунгагийн намтар"-т "Чингис хаан баруун дайлж, Найманыг мөхөөх үеэр Тататунга тамга өвөрлөн зугатаж яваад баригджээ. "Таянгийн улс иргэн, нутаг дэвсгэр цөм минийх болчихсон байтал тамга өвөрлөн зугатах чинь ямар учир вэ? " хэмээн Чингис хаан түүнийг буруушаасанд "Энэ болвоос хуучин эзнээс надад даалгасан тушаал болох тул амь насандаа адилгүй хамгаалбаас зохимуй. Аймшиггүй өөр санаа юун өвөрлөмүй" хэмээн өчсөнд "Үнэнхүү шударга хүн баймуй" хэмээн хаан магтан өгүүлэв. Тамгыг ямар үйлд хэрэглэхийг давтан асууснаа: "Эд агуурсаа зарах, эрдэмтнийг томилох аливаа үйлд итгэмж болгон хэрэглэмүй" хэмээжээ. Түүнийг хаан өршөөн шадар байлгаж, аливаа зарлигийн бичигт тамга хэрэглэх болж, мөн түүнд тушаасан бөлгөө"<sup>8</sup> хэмээн бичигтэн ба "Хар татарын тухай хэргийн товч"-ийн "тамга тэмдэг"-т: "Тэдний тамга нь: зарлигийг тунхаглах эрдэнэ гэсэн тулгарын үсэг сийлсэн гурван ямх илүү тэгш дөрвөлжин тамга юм. Үүнийг Жен хай атгаж, битүүмжийн тэмдэг дарж сэрэмжлэх хэрэг гэж байхгүй, хэрэгт хүнд, хөнгөн хэмээн ялгалгүй бүр хуурмаг түрүү таслана, гэвч Елүй Чуцай, Жүн шан, Еэ хай нар хамтаар татарын эрхийг атгаж, дөрвөн зүгийн хэргүүдийг заримдаа татарын эзний зарлиггүйгээр амьдруулах үхүүлэх, авах өгөх зэрэг эрх нь нэгэнтээ

тамга эрхлэгчдийн гарт шилживэй"<sup>9</sup> хэмээн бичигдэж буй.

Их Монгол ба Их Юань улсын үед хийж бүтээгдсэн Монголын их хаад, Монголын дөрвөн их хан улсын хад, улсын ван, төрийн сайд, цэргийн юаншуай, хааны багш зэрэг хааны соёрхолд багтсан өртөөний тамгууд гэвэл: "Өгөөдэй хааны зарлигийн тамга", "Гүюг хааны зарлигийн тамга", "Буянт хааны зарлигийн тамга", "Аваа ханы зарлигийн тамга", "Аргун ханы зарлигийн тамга", "Хасан ханы зарлигийн тамга", "Өлзийт султаны зарлигийн тамга", "Хааны багш Ринчинрашийн тамга", "Төр захирагч гүнжийн тамга", "Шуан Цай Гүй Цүэ хи ейн тамга", "Шиан жиү Зан хи ейн тамга" зэрэг бий. Эдгээр тамгуудаас "Төр захирагч гүнжийн тамга", "Шуан Цай Гүй Цүэ хи ейн тамга", "Шиан Жиү Зан хи ейн тамга" зэрэг гурван тамга л бодит тамга нь олдсоныг гаргавал, бусад нь цөм бодит тамга нь олдоогүй юм. Үүнд: "Өгөөдэй хааны зарлигийн тамга" бол одоогоор олж мэдсэн хамгийн анхны Монголын их хааны зарлигийн тамга болно. Өгөөдэй хааны арван хоёрдугаар он, тухайлбал он тооллын 1240 онд буулгасан зарлигийн бичгийн хятад эхийн он, сар, өдөр дээр "Huan Di Yu Bao"<sup>10</sup> гэх дөрвөн хятад тулгарын үсэгт "Zhuan Zi" тамга дарж байна. Тус тамгын нүүрийн хэлбэр нь тэгш дөрвөлжин, тамгын нүүр дээр хоёр мөр дөрвөн хятад үсэг бий, дараагийн нүүрийн зүүн талд нь дээрээс доош,

зүүнээс баруун унших журамтай "Huan Di" гэх хоёр үсэг бий ба баруун талд нь мөн дээрээс доош унших журамтай "Yu Bao" гэх хоёр үсэг бий. Энэхүү дээрээс доош, зүүнээс баруун унших журамтай "Huan Di Yu Bao" гэх дөрвөн хятад үсгийг одоох монгол хэлээр орчуулбал: "хааны хас эрдэнэ" даруй "хааны хасбуу тамга" болох юм байна. Энэхүү тамгын бичгийг тус өгүүллийн зохиогч 2009 оны 8-р сарын 10-

«  
*Зарлигийн тамга гэж Их Монгол ба Их Юань улсын үед, Монголын их хаад, Монголын дөрвөн их хан улсын хад, улсын ван, төрийн сайд, цэргийн юаншуай, хааны багш жич, хааны соёрхолд багтсан өртөөний тамга зэрэг албан тамгуудыг зааж буй.*

ны өдрөөс 30-ны өдөр хүртэл хугацаанд олон лавлалтын ном урвуулан байж дахин шинжсэний үр дүнд чадан ядан уншин таньж чадав. "Huan Di Yu Bao" гэдэг бол манай монгол сурвалж бичгүүдэд үргэлж гардаг "хааны хасбуу" тамга гэдэгтэй утга нь яг адил

байна.

"Гүюг хааны зарлигийн тамга" бол уйгаржин монгол үсэгт хамгийн их төлөөлөх чанартай их тамга болно. Энэхүү их тамгыг 1246 онд Гүюг хаанаас Ромын шашны хаан IV Инносентэд илгээсэн зарлигийн бичгийн ард дарсан байна. Тамгыг их гэдгийн учир нь энэхүү тамга бол айхавтар их зарлигийн аястай бөгөөд үг үсгийг их олон хэрэглэсэнд буй. Гүюг хаан Оросын уран дархан Космагаар хааны тамгыг хийлгэсэн тухай Италийн католик шашны элчин Плано Карпини алдарт зохиол [жуулчлалын тэмдэглэл]-доо мэдээлсэн аж<sup>11</sup>. Тус тамгын нүүрийн хэлбэр нь тэгш дөрвөлжин, тамгын нүүр дээр зургаан мөр 19 (үнэндээ 21, зарим дагаврыг нийлүүлэн

бичжээ) уйгаржин монгол үсэг бий. Энэхүү дээрээс доош, баруунаас зүүн унших журамт 19 уйгаржин монгол үсэг бий. Энэхүү дээрээс доош, баруунаас зүүн унших журамт 19 (үнэндээ 21, зарим дагаврыг нийлүүлэн бичжээ) уйгаржин монгол үсгийг одоох монгол бичгээр буулгавал: "Мөнх тэнгэрийн хүчин дор Их Монгол улсын далай хааны зарлиг, ил болго, иргэнд хүрвээс аюутугай!" гэсэн үг болох аж. Эцэг хааных нь "Huan Di Yu Bao" (хааны хасбуу тамга) гэх зарлигийн тамга байж байтал Гүюг хаан юунд энэхүү их тамгыг хийлгэснийг бүү мэд. Энэ нь бараг Гүюгийн төрсөн эх Дөргэнэ хатан төрийн эрхийг дөрвөн жил илүү барьж, Гүюгийг их орд суулгах гэж хүчилсэн улс төрийн хурц ширүүн тэмцэлтэй холбогдолтой байж мэднэ. Учир нь "Гүюг хааны зарлигийн тамга" бол Их Монгол улсын гааль гувчуурын үйлсийг эрхлэх яамны их түшмэл Абдул Лхаманы буулгасан "Мөнх тэнгэрийн хүчин дор их суу залийн ивээлд Абдулын зарлиг, хэн үл бишрэх хүн алдах үхэх"<sup>12</sup> гэх уйгуржин монгол үсэгт мөнгөн гэрэгэний зарлигийн бичигтэй эл талаар их адил төсөөтэй байдагт оршино. "Монгол түүхийн лекц"-д "Өгөөдэй хааны ноёрхлын сүүлийн жилүүдэд араб худалдаачин Абдул Лхаманыг төрд үйлчлүүлж байсан бөгөөд 1240 онд түүнийг эл гааль гувчуурын үйлсийг эрхлэх яамны их түшмэлийн тушаалд томилсон байв. Өгөөдэй хаан нас барсны дараа Дөргэнэ хатан Абдул Лхаманы бүлэгтэнтэй сүлбээлдэн тэдэнд зүйл зүйлийн онц эрх олгож байсан ба ялангуяа Абдул Лхаманы тус бие нь Дөргэнэ хатанд онцгой дотночилогдож байсан аж. Тэр Дөргэнэ хатантай хуйвалдаж, хааны тамгатай үсэггүй зарлигийн хуудсыг олон

хувиар даруулж аваад хааны олон улсын нэрээр хуурмаг зарлигийн бичиг тарааж, ард иргэдийг хянан мөлжиж, харгислан дарлаж байлаа"<sup>13</sup>.

"Гүюг их ор суусны дараа эн тэргүүнд төрийг түйвээсэн Абдул Лхаманыг баривчилж, олны өмнө цээрлэл үзүүлэн цавчин алж", "тусгай зарлиг буулган олон ноёдын дур тааваараа буулгасан зарлигийн бичиг ба пайзан тэмдгийг цөм хураан авав"<sup>14</sup> гэж бичиж буй.

**Т**ийнхүү "Гүюг хааны зарлигийн тамга" бол Дөргэнэ хатан Абдул Лхаман нар сүлбэлдэн хуйвалдаж байсан үеийн улс төрийн бүтээгдэхүүн болох нь боломжтой. "Гүюгийг их ор суулгаж, хааны эрх сүрийг улам их болгохын тулд ийм нэг их тамга хийлгэсэн байх бололцоо бүрмөсөн байна.

"Буянт хааны зарлигийн тамга жич, Аваа, Аргун, Өлзий зэрэг хадын зарлигийн тамгын ул мөр нь татаносын буулгасан буюу илгээсэн зарлигийн бичгийн ард дарагдан байвч, манд олдсон материалуудын гэрэл зургийн эх дэх тамгууд нь маш балархай бөгөөд үсэг нь уншиж болохгүй тул зарлигийн тамгыг нэг нэгээр танилцуулж чадахгүй боллоо. Харин хэлэх ёстой зүйл гэвэл, "Буянт хааны зарлигийн тамга бол "Өгөөдэй хааны зарлигийн тамга" шиг тэгш дөрвөлжин байж, үсэг нь хятад тулгарын үсэг мэт бүүр түүр харагдавч мөр 6 хятад тулгарын үсэгтэй, үсэг нь бүүр түүр тул уншиж болохгүй, харин гайхалтай нь сүүлийн хоёр үсэг нь "Yn Bao" (хас эрдэнэ) хэмээн арай чарай танигдаж байна.

"Хааны багш Ринчинрашийн тамга" бол 1329 онд Тохтөмөр хаанаас Төвдийн Ринчинраш хутагтыг хааны багш (Di Shi)-аар өргөмжлөх үед соёрхсон Төвдийг

дөрвөлжин үсгээр авиачлан бичсэн зарлигийн тамга болно. Их Юань улсын үед хааны багш өргөмжилсөнд "хас тамга" соёрхдог зуршилтай байсан ба хааны багш Төвдийн Ринчинраш хутагт Их Юань улсын Диан ли-гийн хоёрдугаар онд хааны багшаар өргөмжлөгдсөн юм байна. Тамгын нүүрт бүхий 3 мөр дөрвөлжин үсгийг одоох монгол бичгээр буулгавал "Пэгсэ Ринчин бахрашиш" (Хутагт Ринчин бэлгэт)<sup>15</sup> болох юм гэнэ.

"Төр захирагч гүнжийн тамга" бол 1207 онд Онгодод мордон очсон Чингис хааны охин Алга Бэхийн зарлиг тамга болно. Тийнхүү бас "Алга бэхийн тамга" ч гэдэг. Тус зарлигийн тамгыг 1958 онд Өвөр Монголын Хөххотын Үчүан Шианы Дүн То Чен нэгдлийн Ужиа Чيون тосгоноос олж илрүүлсэн байна. Тамгын нүүр тэгш дөрвөлжин, тамгын нүүрт 3 мөр 14 хятад толгойн үсэг буй ба тамгын нүүрийн төв дунд нь хоёр мөр 3 уйгаржин монгол үсэг бий. Эрдэмтдийн уншиж таньснаар бол дээрээс доош, зүүнээс баруун унших журамт 14 хятад үсэг бол "Liu Guo Gong Zhu Ru Xuan Cha He Bei Dou Zong Guan Zhi Yin" болох ба дээрээс доош баруунаас зүүн унших журамт 3 уйгаржин монгол үсэг нь "хас хи яан" (хас тамга)<sup>16</sup> болох юм гэнэ.

"Шуан Цай гүй Цүэ хи еин" тамга бол 1976 онд Өвөр Монголын Улаанцав аймгийн дархан Муулинган холбоот хошууны Төгрөг-Овоо нэгдлийн Сэрүү гэдэг газраас олж илрүүлсэн зарлигийн тамга болно. Тамгын нүүр тэгш дөрвөлжин, тамгын нүүрт хоёр мөр 6 уйгаржин монгол үсэг бий. Эрдэмтдийн уншиж таньснаар бол дээрээс доош, зүүнээс баруун унших журамтай 6 хятад үсэг бол "Xuan Cha Gui Cui Zhi Yin" болох

ба дээрээс доош, баруунаас зүүн унших журамтай 6 уйгаржин монгол үсэг нь "Шуан Цай гүй Цүэ жи еин"<sup>17</sup> болох юм гэнэ.

Дээрх хоёр тамга дахь "Хуан Ча" гэдэг бол "зарлигийн түшмэл" гэсэн үг мөн. "Монгол-татарын тухай бүрэн тэмдэглэл"-ийн "элчинд гарах"-д "Татар элчинд гарснаа Шуан Цай гэнэ"<sup>18</sup> гэж тэмдэглэсэн байна.

**"Ш**иан Жиу Зан Хи Ейн тамга" бол 1981 онд Өвөр Монголын Хөлөнбуйр аймгийн Шинэ барга зүүн хошууны Жавлант нэгдлийн нутгаас олж илрүүлсэн Их Юань улсын үеийн ертөөний тамга болно. Тамгын нүүр тэгш дөрвөлжин, тамгын нүүрт 2 мөр 5 дөрвөлжин үсэг бий. Эрдэмтдийн уншиж таньснаар бол дээрээс доош зүүнээс баруун унших журамт 5 дөрвөлжин үсэг бол "Шиан Жиу Зан Хи ейн" (Xiang Zhou Zhan Zhi Yin)<sup>19</sup> гэх хятад үсэг буй ба хятад үсэг ба тамгын бариулын баруун талд "Xiang Zhou Zhan Yin" гэх хятад үсэг бий ба зүүн талд "Zhong Shu Li Bu Zao, Huna Qing Yuan Nine Jie Yue Ri" гэх үсэг бий. "Huan Qing Yuan Nian" бол их Юань улсын Аюурбадарбал хааны зарлигийн гэрэгэ гэж их Монгол ба Их Юань улсын үед Монголын хаант төрөөс гавьяа зүтгэл бүхий улсын ван, төрийн сайд, цэргийн юаншуай, хааны багш зэрэг чухал хэрэг явдлаар гадаадэд элчилэх хүмүүст соёрхдог онц эрхийн тэмдэг пайзыг зааж буй. Зарлигийн гэрэгэг голдуу зарлиг, захиа уламжлах, зар тунхаг нийтлэх, гааль татвар, алба гувчуур хураах, цэрэг элсүүлэх, дайн зарлах зэрэг чухал хэрэг явдалд хэрэглэхдээ голдуу өртөө улаагаар дамжин явах үед хэрэглэдэг

байна. Гэрэгэ бол эрх сүрийн чухал бэлгэ тэмдэг болох төдийгүй хоёр этгээдийн нийгмийн харилцаанд гэрч тэмдгийн үйлдлийг үзүүлэх дархан эрхт багаж зэвсэг болно.

Зарлигийн гэрэгэний гол онцлог шинж бол мөн "зарлигийн бичиг", "зарлигийн тамга"-тай адил "Мөнх тэнгэрийн хүчин дор хааны нэр хутагт болтугай, хэн үл бишрэх, алдах үхэх!" буюу "Мөнх тэнгэрийн хүчин дор хааны зарлиг, хэн эсэн биширвээс алдтугай" гэх мэт харьцуулшгүй их эрх сүрийг илтгэсэн үг үсгийг хэрэглэсэн байдаг.

**З**арлигийн гэрэгэ эртний үед хятадаар "Fu" (тэмдэг) буюу "Pai (пайз) гэж нэрлэн, монголоор "гэрэгэ" [кегеде] гэж нэрлэдэг байжээ. Зарлигийн гэрэгэ бол байр суурь, зэрэг хэргэм, эрх тушаалыг үзүүлэх үйлдэлтэй тул түүнийг "хос барын тэргүүт алтан гэрэгэ", "арслангийн тэргүүт алтан гэрэгэ", "барын тэргүүт алтан гэрэгэ", "алтан гэрэгэ", "мөнгөн гэрэгэ", "гуулин гэрэгэ" гэж зэрэг дэс ялган, нийтэд нь "урт гэрэгэ" гэж нэрлэдэг ба бас "хайчин гэрэгэ" (алт, мөнгө, төмөр), "төгрөг гэрэгэ" (алтан үсэгт, мөнгөн үсэгт) гэж зэрэг дэс ялган нийтэд нь "төгрөг гэрэгэ" гэж нэрлэдэг байна.

"Урт гэрэгэ"-г соёрхох зэрэг дэсийн ялгаа гэвэл тэргүүн зэргийн сайдад "хос барын тэргүүт алтан гэрэгэ", дэд зэргийн сайдад "арслангийн тэргүүт алтан гэрэгэ", хоёрдугаар зэргийн сайдад "барын дүрст алтан гэрэгэ", дөрөв, тавдугаар зэргийн ноёдод "алтан гэрэгэ", зургаа, долоодугаар зэргийн ноёдод "мөнгөн гэрэгэ", найм, есдүгээр зэргийн ноёдод "гуулин гэрэгэ" гэх мэт.

Их Юань улсын үед цэрэг дайны маш бачим чухал хэрэг явдал тохиолдвол

хаант төрөөс элчин томилохдоо "алтан үсэгт төгрөг гэрэгэ"-г хэрэглэдэг байсан ба энгийн бачим чухал хэрэг явдал тохиолдвол "мөнгөн үсэгт төгрөг гэрэгэ"-г хэрэглэдэг байжээ.

Их Монгол ба Их Юань улсын үед зарлигийн гэрэгэ монгол (уйгаржин, дөрвөлжин), хятад, кидан, перс зэрэг үсэг бичгээр бичиглэдэг байсан бөгөөд алт, мөнгө, гууль, хүрэл, төмөр зэрэг төмөрлөг бодисоор хийж бүтээдэг байжээ. Зарлигийн гэрэгэ-г хийж бүтээсэн уран дархан ба ерөнхий тоо хэмжээг илтгэхийн тулд гэрэгэ-ний ар талын санж (үг)-ийн хавьд "Zi" гэх мэтийн үг үсгийг бичсэн байдаг. Их Монгол ба Их Юань улсын үед Монголын хаант төрөөс хийж бүтээсэн зарлигийн гэрэгэ-г XIX зууны 40-өөд оноос эдүгээ болтол нэгэнт арав гаруйг олж илрүүлээд буй. Үүнд: "Урт гэрэгэ" 7 буй ба "төгрөг гэрэгэ" мөн 7 буй. Их Монгол улсын үед хийж бүтээсэн "урт гэрэгэ"-нүүд гэвэл "Tian Ci Cheng Zhi Hi Huan Di Sheng Zhi Ji" гэх хятад үсэгт гэрэгэ болон "Мөнх тэнгэрийн хүчин дор их суу залийн ихээхэн (ивээл) дор Абдулын зарлиг, хэн үл бишрэх хүн, алдах үхэх" гэх уйгаржин монгол үсэгт гэрэгэ болно. Үүнд "Tian Ci Cheng Zhi Hi Huan Di Sheng Zhi" гэх хятад үсэгт гэрэгэ-г Ке хе мужаас олж илрүүлэв. Гэрэгэний хэлбэр маяг нь ортолжин. Гэрэгэний нүүр талд 3 мөр 10 хятад үсэг бий, дээд дунд мөрт "Tian Ci" гэх 2 үсэг байж, зүүн мөрт "Cheng Zhi Hi Huan" гэх дөрвөн үсэг байж, баруун мөрт "Di Sheng Zhi Ji"<sup>20</sup> гэх мөн дөрвөн үсэг бий. Энэхүү дээрээс доош, зүүнээс баруун унших журамтай 10 хятад үсгийг одоох монгол бичгээр орчуулбал "тэнгэрээс соёрхсон Чингис хааны зарлиг, түргэн!" гэсэн үг болох аж. Гэрэгэний ар нүүр нэг мөр хоёр



хятад үсэг бий. Эрдэмтдийн тайлбар-лахаар бол кидан үсэг нь "Zou Ma" гэсэн утгатай үг болох юм гэнэ.

"Ke xe гэрэгэ" бол Чингис хааны үед хийж бүтээгдсэн цорын ганц хятад ба кидан үсгийн зарлигийн гэрэгэ болно. 1221 онд Өмнөд Сүн улсын элчин Зу Хонгийн бичсэн "Монгол-татарын тухай бүрэн тэмдэглэл" гэх номд "Зүүх алтан пайз гэвэл тэргүүн зэргийн эрхэм сайд бол хоёр бар эсрэгээр хандаж байгаа сийлмэл зурагтай пайзыг зүүмүй. Үүнийг бар гэрэлтэх алтан пайз гэнэ. Дээрх нь хятад үсгээр тайлбал: "Тэнгэрээс соёрхсон Чингис хааны зарлиг, зохисыг үзэн шийтгээрэй" хэмээмүй.

Түүний дараад шулуун алтан пайз болно. Дээрх нь "Тэнгэрээс соёрхсон Чингис хааны зарлиг, түргэн" гэсэн үсэгтэй.

Бас дараад нь мөнгөн пайз болно. Утга нь урьдахтай адил юм<sup>21</sup> хэмээн бичигдэж буй. Үүнд "Тэнгэрээс соёрхсон Чингис хааны зарлиг, түргэн" гэх шулуун алтан пайз нь даруй дээрх "Ke Xe гэрэгэ"-ний зарлигийн бичгийн агуулгатай ив ижил байгаа юм. "Мөнх тэнгэрийн хүчин дор их суу залийн ивээн (ивээл) дор автлын зарлиг, хэн үл бишрэх хүн алдах, үхэх" гэх уйгаржин монгол үсэгт гэрэгэ бол дээр нэгэнт хоёрдугаар хэсэгт урьдчилан илхэн өгүүлсэн мэтээр тус зарлигийн гэрэгэ бол их Монгол улсын үеийн цорын ганц уйгаржин монгол үсгээр бичигдсэн зарлигийн гэрэгэ болно. Тус мөнгөн гэрэгэг 1845 онд Оросын Днепр мөрний орчмоос олж илрүүлэв. Гэрэгэний нүүр талд "Мөнх тэнгэрийн хүчин дор их суу залийн ивээл дор" гэх 11 уйгаржин монгол үсэг буй ба гэрэгэний ар талд мөн "Авдулын зарлиг, хэн үл бишрэх хүн алдах, үхэх" гэх 9 уйгаржин монгол үсэг бий. Энэхүү дээрээс

доош, баруунаас зүүн унших журамтай 20 уйгаржин монгол үсгийг одоох монгол бичгээр буулгавал "Мөнх тэнгэрийн хүчин дор их суу залийн ивээл дор" гэх 11 уйгаржин монгол үсэг буй ба гэрэгэний ар талд мөн "Авдулын зарлиг хэн үл бишрэх хүн алдах үхэх" гэх 9 уйгаржин монгол үсэг бий. Энэхүү дээрээс доош, баруунаас зүүн унших журамтай 20 уйгаржин монгол үсгийг одоох монгол бичгээр буулгавал "Мөнх тэнгэрийн хүчин дор их суу залийн ивээн (ивээл) дор Авдулын зарлиг, хэн үл бишрэх хүн алдах, үхэх" гэсэн үг болох аж. "Ke xe гэрэгэ" болон "Днепр гэрэгэ" бол Их Монгол улсын үеийн хамгийн их төлөөлөх чанартай зарлигийн гэрэгэ болно.

**И**х Юань улсын үед хийж бүтээгдсэн дөрвөлжин үсэгт "Урт гэрэгэ" нүүд гэвэл 1846 онд Оросын Енисей Жиугийн Минусинскээс олдсон "Минусинск гэрэгэ", 1853 онд Оросын Байгаль нуур хавийн Неүкээс олдсон "Неүк гэрэгэ", XX зууны 90-ээд оны эхэнд Өвөр Монголын Улаанцав аймгийн Чин Шүй Хе-гээс олдсон "Чин Шүй Хе гэрэгэ", XX ба XXI зууны уулзвар дээр Өвөр Монголын Хянган аймгийн Солонноос олдсон "Солон гэрэгэ", XX зууны 50-иад оны сүүлчээр Сычуань мужийн Аваас олдсон "Ава гэрэгэ" зэрэг буй.

Үүнд "Солон гэрэгэ" ба "Ава гэрэгэ" бол Их Юань улсын үеийн дөрвөлжин үсэгтэй "Урт гэрэгэ"-нүүдийн доторх хамгийн их төлөөлөх чанартай зарлигийн гэрэгэ болно. Төлөөлөх чанартай гэдгийн учир бол нэг нь "Алтан гэрэгэ", нөгөөх нь "гуулин гэрэгэ" болоход оршино.

"Солон гэрэгэ" бол «Алтан гичтэй, урт дөрвөлжин, уртаараа 25,7 см, өргөнөөрөө 8,1 см, зузаанаараа 0,1 см, хүндээс

рээ 384 гр, ар өвөр хоёр талд нийт 5 мөр давхар угалз дөрвөлжин үсэгтэй, холбон уншиж болно. Дээр хэсэгтээ оосорлож дүүжлэх төгрөгхөн нүхтэй. Төгрөгхөн нүхэндээ эргэж болох гархи чимэглэлтэй»<sup>22</sup> тус гэрэгэний «А талд нь гурван мөр үсэгтэй, дундах нь өндөрлүүлэн бичсэн толгой үг, нэгдүгээр мөр болох ёстой, В талд нь хоёр мөр үсэгтэй, холбон уншвал нэгэн бүрэн бүтэн утгыг илтгэнэ»<sup>23</sup>. Гэрэгэ дээрх дээрээс доош, зүүнээс баруун унших журамтай таван мөр 14 дөрвөлжин үсгийг одоох монгол бичгээр буулгавал "Мөнх тэнгэрийн хүчин дор хаан нэр хутагтай болтугай, хэн үл бишрэх алдах, үхэх" гэсэн үг болох аж. Гэрэгэний ар талын чимэглэл гархи дээр "Zhang Zi Jiu Hao" гэх 6 хятад үсэгтэй. Энэ нь гэрэгэг хийж бүтээсэн уран дархны овог ба ерөнхий дугаарлал болох аж. "Ава гэрэгэ" бол «ортолжин хэлбэртэй. Гэрэгэг зэсээр үйлджээ. Түүний урт 25 см, өргөн 8,2 см, дээр талын оосрын сүвийн хэсэг нь дотогшоо хумигджээ. Энэ нь манай мэдээжийн алтан мөнгөн гэрэгэний гадар дүрсээс багахан зөрөөтэй. Гэрэгэний хоёр талд 5 мөр дөрвөлжин үсэг сийлэгдсэн нь харин тэдгээр алтан мөнгөн гэрэгэнүүдтэй эгээ адил байна»<sup>24</sup>. Гэрэгэ дээрх дээрээс доош, зүүнээс баруун унших журамтай таван мөр 14 дөрвөлжин үсгийг одоох монгол бичгээр буулгавал "Мөнх тэнгэрийн хүчин дор хаан нэр хутагтай болтугай, хэн үл бишрэх, алдах үхэх" гэсэн үг болох аж.

Их Юань улсын үед хийж бүтээгдсэн дөрвөлжин үсэгт "Төгрөг гэрэгэ"-нүүд гэвэл 1881 онд Оросын Томск хотын хавь дахь Боготолоос олдсон "Боготол гэрэгэ", ХХ зууны тавиад оны сүүлчээр Сычуань

мужийн Аваас олдсон "Ава гэрэгэ", 1973 онд Төвдөөс одсон "Төвд гэрэгэ", 1995 онд Төвдийн Рашилхүмбэ хийдээс олдсон "Рашилхүмбэ гэрэгэ", жич Америкаас олдсон "Америк гэрэгэ" зэрэг бий. Үүнд "Рашилхүмбэ гэрэгэ" бол алтан үсэгт дөрвөлжин үсгийн төгрөг хэлбэртэй төмөр гэрэгэ байж, "Төвд гэрэгэ" бол мөнгөн үсэгт дөрвөлжин үсгийн төгрөг хэлбэртэй төмөр гэрэгэ болох юм байна. "Төвд гэрэгэ" (одоо Гасү мужийн музейд хадгалагдаж байгаа) энэ пайз өндрөөрөө 18 см, өргөнөөрөө 11,7 см, хүнд нь 249 гр буй. Пайзыг төмрөөр үйлдэж, мөнгөөр өнгөлжээ. «Пайзын нүүр талд зүүнээс баруун мөнгө ширсэн дөрвөлжин үсэг нийт 5 мөр, 12 үгтэй. Үсгийг дээрээс доош монголоор тэмдэглэжээ»<sup>25</sup>. Гэрэгэ дээрх 12 дөрвөлжин үсгийг одоох монгол бичгээр буулгавал "Мөнх тэнгэрийн хүчин дор хааны зарлиг, хэн эс биширвээс алдтугай" гэсэн үгтэй болох аж.

"Ава гэрэгэ" бол төгрөг хэлбэртэй зэс гэрэгэ болно. «Гэрэгэний гархи хүртэлх өндөр нь 18,4 см, диаметр нь 11,7 см, гархиас доторх бариулын хэсэгт нь барын тэргүүний дүрстэй. Гэрэгэний хоёр талд тус бүр таван мөр дөрвөлжин үсэгтэй, нэг талд нь зөв тэг, нөгөө талд нь тонгоруу тэгтэй»<sup>26</sup>. Гэрэгэ дээрх дээрээс доош, зүүнээс баруун унших журамтай 12 дөрвөлжин үсгийг одоох монгол бичгээр буулгавал "Мөнх тэнгэрийн хүчин дор хааны зарлиг, хэн эс биширвээс алдтугай" гэсэн үг болох аж.

Их Юань улсын үед хийж бүтээгдсэн олон үсэгт "Зар тунхаг гэрэгэ" ба "Мохрох гэрэгэ" хоёр олдсоны нэг нь Бээжингээс олдсон "Зар тунхаг", мууныг сэтэрдэх

хэрэг ба нөгөө нь Яань Жиу-аас олдсон гэрэгэ болно.

"Бээжин гэрэгэ" бол "сэрэмж өгөх" хэрэг болно. «Гуулиар үйлдсэн энэхүү төгрөгөн гэрээг уул нь Бээжингээс олжээ. Хожим нь Зөвлөлтөд дамжин очив»<sup>27</sup>. Гэрэгэний нүүр талд нь гурван зүйлийн үсэг бий. Төв дунд нь дээрээс доош, баруунаас зүүн унших журамтай хоёр мөр таван дөрвөлжин үсэгтэй байж, зүүн талд нь мөн дээрээс доош, баруунаас зүүн унших журамтай хоёр мөр таван уйгаржин монгол үсэг бий ба баруун талд нь дээрээс доош унших журамтай дөрвөлжин ба уйгаржины агуулгатай ижил нэг мөр перс үсэг бий. Гэрэгэ дээрх дөрвөлжин ба уйгаржин үсгүүдийг одоох монгол бичгээр буулгавал, тэдгээр нь бүр "зар тунхаг, мууныг сэрэгдэх" гэсэн үгнүүд болно. Гэрэгэний санжаас доорх хэсэгт гарьдын толгойтой бөгөөд үсгийн дөрвөлжин хүрээний гадуур угалзан чимэглэлтэй.

Гэрэгэний ар талд төв дунд нь хятадаар "Ling" гэх үсэг бий ба хоёр хажууд нь дээрээс доош зүүнээс баруун унших журамтай хоёр мөр арван хоёр хятад үсэг бий. Үүнийг холбон сийрүүлбэл: "Xi Kou Fang Jian Bu Zhan Dun Dai Da Zhe Zhi Zui" гэсэн үг болох юм байна. Мөн ар талын зүүн ирмэгт "Kou Zi Gan Qi" гэх уран дархан ба гэрэгэний ерөнхий дугаарлалтай ("Wen Wu" гэх дөрвөлжин тэмдгүүд нь балархай үсэг) "Янг зиү гэрэгэ" бол "Цагдах гэрэгэ" болно. «Түүхэн дурсгалт зүйл» (Yuan Dai Yao Pai) хэмээгч сэтгүүлийн 1962 оны 11 дүгээр хугацаанаа нийтлэгдсэн Яанг жиү хотын хэрмээс малтан гаргасан «Юань улсын үеийн зүүн шошго» (Yuan Di Yao Pai)-ийг

харин хүрлээр хийсэн байв»<sup>28</sup>. Гэрэгэний нүүр талд дунд нь дээрээс доош унших журамтай "Xuan Wei Shi Shi Si Dou Yuan Shuai Fu" гэх нэг мөр найман хятад үсэг бий ба хоёр хажууд нь дээрээс доош, зүүнээс баруун унших журамтай хоёр мөр найман хятад үсэг бий. Үүнийг холбон сийрүүлбэл: "Gong Wu Ji Su Chi Ci Ye Xing" гэсэн үг болох юм байна. Мөн ар талын баруун захад "Xuan Zi Shi Hao" гэх уран дархан ба гэрэгэний ерөнхий дугаарлалтай.

### Ишлэл

1, 9, 18, 21 1979. Монгол-татарын тухай бүрэн тэмдэглэл. Хар татарын тухай хэргийн товч (Мөнхзаяа орчуулав). Харбин, Хар мөрний ардын хэвлэлийн хороо. 231, 186, 93, 81 дэх тал.

2, 4, 7, 10, 11, 12 Т о в у у. 1983. Уйгаржин монгол үсгийн дурсгалт бичгүүд. Бээжин. Үндэстний хэвлэлийн хороо. 9, 13, 31, 9, 13, 415 дахь тал.

3 С а й ш а а л. Монголын их хааны алтан тамга // "Монгол хэл бичиг" сэтгүүлийн 1980 оны 4-р хугацаа.

5, 6, 15, 16, 17, 27 Ц о л м о н. 1996. Монгол тамга сийлмэл. Хөх хот, Өвөр Монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо. 46, 51, 12, 9, 9, 56 дахь тал.

8 1976. Юань улсын түүх (хятад хэвлэл). Зүнхуа бичгийн товчоо, 3048 дахь тал.

13, 14 Д а м б а нар. 1993. Монгол түүхийн лекц. Хөх хот, Өвөр Монголын их сургуулийн хэвлэлийн хороо. 143, 146 дахь тал.

19 Х о с б а а т а р. Хөлөнбуйр аймгаас олдсон Шианжу өртөөний тамгад холбогдох хэдэн асуудал // "Монгол хэл утга зохиол" сэтгүүлийн 1986 оны 2-р хугацаа.

20, 25, 28 Х у с о м и н. Дөрвөдөөс олдсон дөрвөлжин үсгийн төгрөг пайзын тухай // "Монгол хэл бичиг" сэтгүүлийн 1981 оны 2-р хугацаа.

22, 23 2002. Оюуны цэцэгсийн баглаа (өгүүлийн түүвэр). Хөх хот, Өвөр Монголын

их сургуулийн хэвлэлийн хороо. 331, 332

дахь тал.  
2026 Захдай Чимэддорж.  
Дөрвөлжин үсгийн зэс гэрээ хийгээд "алдах"  
гэх үгийн тухай // "Өвөр Монголын их  
сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл"-ийн  
2009 оны 4-р хугацаа.

### Резюме

Данная статья посвящена трём инфор-  
мационным символам и великодержавным

гарантам монгольской почтовой службы XIII  
века — грамоте высочайшего повеления,  
печати высочайшего повеления и гэрэгэ  
высочайшего повеления. Автор подробно и  
детально описывает их признаки и  
отличительные черты. Автор, на основании  
собственных исследований, выдвигает  
версию о том, что почтовая служба,  
созданная для обеспечения населения  
оперативной информацией, является прото-  
типом современной всемирной паутины —  
Интернета.